

## 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

### Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

**Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяр, Засаг дарга М.Идэрбат нараар ахлуулсан ажлын хэсэг сумдад 01 дүгээр сарын 11-16-ны өдрүүдэд ажиллан өвөлжилт, цаг үеийн байдалтай танилцлаа. Мөн аймгийн Засаг дарга М.Идэрбат энэ сард 28 агентлаг, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэх ажлыг тусган батлуулж, Канад улсын "Мерит" төсөл болон Монголын Чанарын удирдлагын зөвлөхүүдийн холбоо зэрэг байгууллагатай нягт хамтран ажилласаны үр дүнд Олон улсын итгэмжлэлийн байгууллага (IAF) -ын гишүүн байгууллага болох “МонСертф” ХХК-аас 3 жилийн хугацаатай “Баталгаажуулалтын гэрчилгээ”-г 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүлээн авлаа.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо “ISO 9001:2015” олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартын шаардлагын хүрээнд холбогдох журмууд болон байгууллагын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, стандартыг амжилттай хэрэгжүүлэх гол хүчин зүйл болох албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн идэвхжүүлэлтийн арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулж, хамт олон, албан хаагчдын идэвх санаачилгыг өрнүүлж, багийн ажиллагааг идэвхжүүлэн ажилласнаар аймгийн хэмжээнд Баталгаажуулалтын гэрчилгээтэй 2 дох байгууллага болсон байна.

Аймгийн ЗДТГ өөрийн үйл ажиллагаандаа төдийгүй бусад төрийн захиргааны байгууллагуудад ЧМТ-ны “ISO 9001:2015” олон улсын стандартыг нэвтрүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн 2021 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд сумдын ЗДТГ-т "ISO 9001:2015" олон улсын Чанарын менежментийн тогтолцоо стандартыг үе шаттай нэвтрүүлж, баталгаажилт хийлгэх арга хэмжээг тусгасанаар энэ онд Баруун-Урт, Мөнххаан, Дарьганга зэрэг сумд ЗДТГ-ын үйл ажиллагаандаа уг стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэхэд бэлэн болсон байна.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем “ERP”-ийн нэвтрүүлэлт, ашиглалтын гэрээг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хийж баталгаажуулан хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын 48 албан хаагч ERP системд бүртгэгдэж Төрийн албан хаагчийн А, Б анкетаа шивж оруулан, системээр дотооддоо мэдээ мэдээлэл болон албан бичиг солилцож өдөр тутам ашиглаж эхэллээ. Түүнчлэн эдгээр албан хаагчдад төрийн байгууллагын цахим шуудан “вэбмэйл” хаягийг олгосон бөгөөд өөрсдийн хэрэглээний нууц үгээ үүсгэж байгууллага хооронд цахимаар албан бичиг солилцож эхэлсэн. Мөн аймгийн ИТХ-ын 16 албан хаагчдад вэбмэйл хаяг нээж мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгсөн.

Агентлаг, төсөвт байгууллагууд, ӨНӨҮГазрууд, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, сумдын бичиг хэрэг зэрэг 72 төрийн албан хаагчдад вэб мэйл хаягийг нээж албан бичгийг цахимаар солилцож цаг алдалгүй түргэн шуурхай хүрч байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар дамжуулан иргэдэд цаг үеийн үйл явдал болон цар тахалтай холбоотой 33 удаагийн мэдээ мэдээлэл, зөвлөмжийг хүргэж ажилласан ба давхардсан тоогоор 110 мянган хүнд хүрсэн байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “Аймгийн аварга малчин”-аар шалгаруулах журмын дагуу сумдаас ирүүлсэн 43 малчны тодорхойлолт материалыг хэлэлцэн, журмын болзол шалгуурыг хангасан 32 малчныг “Аймгийн аварга малчин”-аар шалгаруулсан байна.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:** Сүхбаатар аймгийн 2021-2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн зорилтот түвшинг бодлогын хэлтсүүдээс хүлээн авч болон улсын орон нутгийн бодлогын баримт бичигүүдтэй уялдуулан тодорхойлж ЗГХЭГ-т хүргүүлэв.

Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу 13 сум, 27 агентлаг, төсөвт байгууллагын 2020 үйл ажилллагааны хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авсан.

Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулсан. Нийт 91 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 183 заалтыг хяналтад авч 97,14 хувийн биелэлттэйгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахим болон цаасаар, дагалдах материалын хамт хүргүүлээ.

Агентлаг, сумдын 2020 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудаар шинэчлэн баталсан Стратеги төлөвлөгөө болон байгууллага, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах, тайлан гаргах журмуудыг хэрэгжүүлэхэд баримтлах аргачлал, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын талаар ЗГХЭГ-аас зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг, төсөвт байгууллагын нийт 71 төрийн албан хаагчийг халдвар хамгааллын дэглэм сахиулсаны үндсэн дээр хамрууллаа.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажилллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, Сүхбаатар аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Засаг даргын зөвлөлийн хуралаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т цаасан болон цахим хэлбэрээр хугацаанд нь хүргүүлэв.

**Төрийн албаны салбар зөвлөл:** Төрийн албаны удирдах албан тушаалын - 4, дэс түшмэлийн -25, туслах түшмэлийн 15 ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулахаар зарласан. Үүнд 32 иргэн материалаа ирүүлсэнээс шаардлага хангасан 25 иргэнийг бүртгэж, шалгалтад хамгийн өндөр оноо авч тэнцсэн 17 иргэнийг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж санал болгосон.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтын бүртгэлийн үйл ажиллагаа 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлээд байна. Энэ хүрээнд орон нутгийн телевиз, facebook групп, цахим сайт зэрэг мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгаа хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Төрийн албаны хууль, бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр Төрийн албаны салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар аймгийн 13 суманд ажиллалаа.

#### **Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

2021 оны 1 дүгээр сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 3,336.4 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 1,347.6 сая төгрөгийн орлого орж нийт 4,684.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Аймгийн төсвөөс сумдад 573.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 4,138.1 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

13 төсвийн шууд захирагчийн 2020 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажил хийгдэж байна.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд аймгийн хэмжээнд 132 байгууллага нэвтэрсэнээс 130 байгууллага цалингаа өндөрлөсөн байна. Шүүхийн тамгын газар, Биеийн тамир, спортын газар зэрэг байгууллага нь 2021 оноос шинээр нэвтэрч байгаа тул онлайн сургалтдаа хамрагдаж 2 сараас эхлэн системээр цалингаа авахаар төлөвлөж байна.

Сумд болон байгууллагуудын 2021 оны төсвийн орлого зардлын хуваарийн саналыг байгууллага бүрээр гаргуулан хянан хүлээж авч боловсруулан аймгийн Засаг даргын 2021 оны А/24 дүгээр захирамжаар төсвийн сар улирлын хуваарийг батлууллаа.

Төсвийн сарын хуваарийг төсвийн төлөвлөлтийн программд байгууллага, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал тус бүрээр оруулж 2021 оны төлбөр тооцоог гүйцэтгэхэд бэлэн болгож ажиллалаа.

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн цахим системд 2019-2020 онд шинээр үүссэн 20 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэж, 15 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг шинэчиллээ.

#### **Татварын хэлтэс:**

2021 оны улсын төсөвт 197.2 сая төгрөг төлөвлөгдөж 223,7 сая төгрөг төвлөрүүлж 113.5 хувиар, Орон нутгийн төсөвт 591,1 сая төгрөг төлөвлөгдөж 682,3 сая төгрөг төвлөрүүлж 115.4 хувиар тус тус биелүүлсэн байна.

2021 онд ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан 2 сарын 15-ны дотор цахимаар авч байгаатай холбогдуулан татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх нээлттэй утсыг иргэдэд зарлаж, утсаар болон эмайл хаягаар, ажлын байранд нь, хэсэгчилсэн, танхимаар татвар төлөгчдөдд заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

**Орон нутгийн өмчийн газар:** Орон нутгийн өмчит 141 хуулийн этгээдийн 2020 онд хийгдсэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийн мэдээг жилийн эцсийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан ажиллаж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх, хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийж эдийн засгийн хувьд үр ашиггүй хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний хуралдаанаар хэлэлцүүлж Үндсэн хөрөнгө худалдах, шилжүүлэх, актлах зөвшөөрөл олгох тухай, Хөрөнгө бүртгэх, эзэмшүүлэх зөвшөөрөл олгох тухай шийдвэрүүдийг гаргуулсан. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 322,801,642.72 /Гурван зуун хорин хоёр сая найман зуун нэгэн мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг далан хоёр мөнгө/ төгрөгийн эд хөрөнгийг актлаж данснаас хасах зөвшөөрөл олгож байгууллагуудад хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний А/684 дүгээр захирамжаар батлагдсан “2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу 2021 оны 01 дүгээр сард 13 сумын [“Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах”](#) тендерийн урилгыг tender.gov.mn сайтаар дамжуулан зарлаад байна.

**Санхүүгийн хяналт, аудитын алба:** Авлигатай тэмцэх газрын тогтоолын дагуу Санхүүгийнхяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод адитор Д.Оюунсүрэн эдийн засгийн шинжээчээр томилогдон Сүхбаатар үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийж ажиллалаа.

**Статистикийн хэлтэс:** Албан ёсны статистикийн 1-р сарын 4-ний өдөр явах мэдээнүүдийг анхан шатны нэгжээс цуглуулан авч, хянан шалгаж шивэлтийг бүрэн хийж дамжуулсан.

Аймгийн нийгэм эдийн засгийн жилийн эцсийн 2020 оны танилцуулгыг салбар бүрийн гол гол үзүүлэлтүүдээр нэгтгэн 2021 оны 01-р сарын 20-нд хэвлэн тархаан ажилласан.

2021 оны 1 дүгээр сарын 5-аас 2021 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд 13 сумын жилийн эцсийн мал тооллого, хүн амын материал тушаах хуваарийг гаргаж хуваарийн дагуу сумдуудын материалыг хянан шалгаж хүлээн авсан.

Малын ашиг шимийн судалгаанд хамрагдсан 8 сумын 220 өрхийн 2960 дэвтэр маягтыг 2021 оны 01 дүгээр сарын 11-нээс 28-ны өдрүүдэд мал тооллого болон ХАА-н мэдээтэй тулган хүлээн авч шивэлтийг 30-ны дотор бүрэн хийж дууссан.

Малчид тэтгэвэрт гарах ажилласан жилээ нөхөн тооцуулахтай холбогдуулж 2008-2019 оны малын А дансны мэдээлэлээ гаргуулах хүсэлтэй 12 иргэн өргөдөл өгснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

2020 оны 12 дугаар сарын өрхөд суурилсан судалгааны 112 өрхийн мэдээллийг шалган 2021 оны 1 сарын 3-нд дамжуулсан. 2021 оны өрхөд суурилсан судалгааны 1-р сарын мэдээлэл цуглуулалтын ажлыг Баруун-Урт сумын 4-р багийн ӨНЭЗС-ны 10 өрх, 8-р багийн АХС-ны 10 өрхийн судалгааг бүрэн авч дуусгасан.

### **Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:**

**Боловсрол, соёл урлагийн чиглэлээр:** 2020-2021 оны хичээлийн жилийн II улирлын хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхэд багшид тулгамдаж болох асуудлуудыг эрэмбэлэн тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор санал дүгнэлтийг судлагдахуун бүрээр авч нэгтгэн Боловсролын хүрээлэнд хүргүүлсэн.

БШУЯ, Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан "ЕБС-ийн хүүхэд хөгжлийн танхимд ажиллах багш нарыг чадавхжуулах" 5 өдрийн сургалтад 2 мэргэжилтэн, 6 багш, БҮТ, БМДИ-гээс зохион байгуулсан цахим хэлэлцүүлэгт бүх мэргэжилтнүүд 7 хоногт 2 удаа оролцсоны зэрэгцээ Багшийн хөгжил, БМДИ-ээс ЕБС, СӨБ-ийн багш ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх сонголтот сургалтад Сүхбаатар аймгаас нийт 388 багш, 38 удирдах ажилтан, 41 бусад ажилтнууд хамрагдсан.

Ерөнхий боловсролын 16 сургууль, 24 цэцэрлэг, 12 соёлын төвүүдийн 2020 оны үйл ажиллагааны тайланг 4 чиглэлээр хүлээн авч хяналт, шинжилгээ хийж үнэлгээ өгсөн.

2020-2021 оны хичээлийн жилийн шилдэг илтгэлийн 1-р шатны уралдааныг "**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ: /Танхимын ба цахим хичээл/ АСУУДАЛ, ШИЙДЭЛ**" сэдвийн дор зохион байгуулж үнэлсэн.

Орон нутгийн BBS телевизтэй хамтран 6 судлагдахуунаар цахим хичээлийн контент бэлтгэх ажлыг эхлүүлсэн.

**Угсаатны зүйн музей:** Аймгийн Төрийн аудитын газарт санхүүгийн тайланг гаргаж хүргүүлсэн.

"Дарьганга өв соёл" сэтгүүлийн 2021 оны анхны дугаарын эх бэлтгэх ажил хийгдсэн.

Цахим орчин соёл түгээе аяны хүрээнд Ардын хувьсгалын 100 жил, Д.Сүхбаатарын мэндэлсний 128 жилийг угтан Д.Сүхбаатарын нэрэмжит танхимд дэглээтэй байгаа уран зургуудыг тайлбартайгаар олон нийтэд хүргэсэн.

**Хөгжимт жүжгийн театр:** Аймгийн ЗДТГ, BBS телевизтэй хамтран "Цагаан сар" баярын теле концертын бэлтгэл ажил хийгдэж байна.

Байгууллагын ажилтан алба хаагчид морин хуур, ёочин, хөөмийн сургалтанд хамрагдаж байна.

**Нийтийн номын сан:** Лавлагаа ном зүйн үйлчилгээний хүрээнд цахим хуудсаар нэг сарын хугацаанд 3130 удаа пост оруулан ажилласан ба 15020 хүн хандсан байна

Хүүхдийн уншлагын танхимд цахим хаяг нээж, хүүхдийн зохиолч Г.Ловорын намтар уран бүтээлийг сурталчлан цахимаар мэдээлэл оруулахад нийтдээ 977 хүнд хүрсэн байна.

Ном сэлбэн засах ажлын хүрээнд нийтийн уншлагын танхимын 30, хүүхдийн уншлагын танхимын 10, гэрээр ном олгох танхимын 20 ширхэг номыг номыг сэлбэн засварласан.

Сум, сургуулийн номын санчдын 2020 оны ажлыг дүгнэсэн.

**Хөдөлмөр эрхлэлтийн талаар:** 2021 оны 01-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 511 иргэнээс эмэгтэй 247, бүртгэлтэй ажилгүй иргэн 399 иргэнээс, эмэгтэй 195 иргэн байна. 30 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 23 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 21 нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 8 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлээ.

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн 1,243,202.4 мянган төгрөгний авлагын тулган баталгаажуулалтыг сумдаар гаргаж еwork системээр сумдад хүргүүлж иргэн бүртэй үлдэгдлийг тулган баталгаажуулалтыг хийж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүгийн дэмжлэгийн авлагын насжилтын судалгаа, хөдөлмөрийн тухай хуулийн 111-р заалтын дагуу төлбөр төлсөн 5 аж ахуй нэгж байгууллагын 44518.8 мянган төгрөгний судалгаа, жилийн эцсийн кассын нэгтгэл, хоорондын тооцоог гарган ХХҮЕГ-ын санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас бодлогын шинэчлэлийн хүрээнд "Халамжаас-Хөдөлмөрт шилжинэ" гэсэн зорилтын дагуу аймгийн хэмжээнд ажил хайгчаар бүртгэлтэй иргэдийг мэргэжил болон хийх ажлын төрлөөр нь ангилах судалгааг гаргаж нэгтгэлээ.

Баруун-Урт сумын “Сүхбаатарт үйлдвэрлэв борлуулалтын цэг”-ийн гэрээг шинэчлэн байгууллаа. Баруун-Урт сумын “Борлуулалтын цэг”-ийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор цахим хаягыг сэргээж үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон аймгийн том зарын хуудсуудад байршуулсан.

Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг төрийн банкаар дамжуулан олгосон хувиараа бизнес эрхлэгчдийг сурталчилах зорилгоор цахим телевизээр бичлэгийг туршилтын хөтөлбөрийн 4, залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг 1, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 1 нийт 6 хувиараа бизнес эрхлэгчээс авч нэвтрүүлгийг цахимаар иргэд олон нийтэд сурталчилж эхлээд байна.

**Нийгмийн халамжийн талаар:** 2021 оны 01 дүгээр сард нийгмийн халамжийн үйлчилгээ авахаар давхардсан тоогоор 1500 иргэн цахимаар болон өөрийн биеэр ирж үйлчлүүлсэн байна. 01 дүгээр сард олгох 1322 иргэний 368,526,090 мянган төгрөгийн тэтгэвэр, 1356 иргэний 148,071,530 мянган төгрөгийн тэтгэмж, 25 иргэний 3,290,000 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 245 иргэний 12,693,360 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийг банк илгээсэн. Нийгмийн халамжийн мэдээллийн системээр олгогдох 611 иргэний 23,388,726 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 3166 иргэний 154,611,716 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн, 2 иргэний 600,0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмжийн жагсаалт гарган тулган баталгаажуулж төрийн сан илгээсэн.

Шинээр 65 нас хүрч буй 145 ахмад настнуудын жагсаалтыг сумдын багийн дарга нараас хүлээн авч өөрийн карттай дансыг нь холбон насны хишгийн үйлчилгээг бүртгэсэн.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/1733 албан тоот чиглэл ирсний дагуу 2021 онд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх 13 сумын 18 хүнсний дэлгүүрийн, Баруун-Урт, Эрдэнэцагаан сумдын хүнсний дэлгүүрийн багц, хамрагдах өрх, иргэний батлагдсан санхүүжилтийн хуваарь, ХХҮЕГ-с ирүүлсэн чиглэлийг Орон нутгийн өмчийн газарт албан бичгээр хүргүүлж Орон нутгийн өмчийн газраар сонгон шалгаруулах тендерийг зарлахаар төлөвлөгөөнд нь батлуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 онд хуралдах хуралдааны календарьчилсан төлөвлөгөөг батлан гаргасан.

E-halamj хэрхэн бүртгүүлэх болон, насны хишиг Алдарт эхийн одон олгохтой холбоотойгоор иргэдийг картжуулах талаар шторк, гарын авлага бэлтгэн цахимаар иргэдэд хүргэсэн. Ажлын байранд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж 15ш хэвлэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүр болон банкнууд, томоохон худалдааны төвүүдэд нааж байрлуулсан.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрүүл мэндийн байгууллагуудын Коронавируст /Covid-19/ халдварын үеийн бэлэн байдлыг хангах, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, дадлыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн салбарыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж төрийн болон хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт хяналтыг хийж бэлэн байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх, тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

2021 оны 1 дүгээр сард 13 сумын хэмжээнд 1067 иргэнийг гэрийн ажиглалтад авч, өрх болон сумын ЗДТГ, Улаан загалмайн хороо бусад мэргэжлийн байгууллагууд хяналт тавин ажиллаж байна.

Жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр хийх ажлын чиглэлийг тодорхойлох зорилгоор 2018-2020 оны хооронд жирэмсний хяналтад хожуу орсон эхчүүдийн судалгааг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран нэг бүрчлэн судалж дүгнэж байна. Мөн 0-5 насны хүүхдийн суурь судалгааг гаргаж өвчлөлийн тэргүүлэх шалтгаанаар нь ангилаад байна.

Орон нутгийн телевиз, Сүхбаатарын өнгө сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулж, цаг үеийн асуудлаар 5 удаа шууд нэвтрүүлэг, 12 төрлийн шторкыг өдөрт 8-10 удаагийн давталттай явуулж, сонинд 7 хоног бүр мэдээлэл өгч, цахимаар иргэдэд зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад 8 удаагийн цахим сургалтыг явуулж анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг бодлого чиглэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллаа.

Халдварт саагийн идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах 3750 хүн тун вакциныг хүлээн авч өрх, сумын ЭМТ-үүдэд хуваарилан аймгийн хэмжээнд 1 дүгээр сарын 28-ны байдлаар дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхдийн 50%-ийг хамруулаад байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлийг хуралдуулан 2 иргэний тэтгэвэр тогтоолгоход гарсан асуудлыг шийдвэрлэлээ.

2021 онд Эрүүл мэндийн салбарт Орон нутгийн хөрөнгөөр худалдан авалт хийгдэх ажлуудын техникийн тодорхойлолтыг гаргалаа.

Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хурлыг хийж 5 байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг сунгалаа.

2021 оны 1-р улиралын Ерөнхий гэрээний эм, эмнэлгийн хэрэгслийг 11 компаниас татан авч сумын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн ажиллаж байна.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2021 оны анхдугаар хурлыг зохион байгуулж, 2020 онд хүүхэд холбогдсон хэргийн нөхцөл байдлын шийдвэрлэлтийн талаар танилцуулж, 2021 оны ажлын төлөвлөгөөг батлан, аймгийн ГХУСАЗСЗ-ийн дэргэд Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр дэд хороо байгуулах саналыг хэлэлцэж аймгийн ИТХ-ын ажлын албанд саналаа хүргүүлэхээр шийдвэрлэв.

Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн судалгааг гаргаж, 01 сарын байдлаар Мал эмнэлэгийн газар, Мөнххаан сумын ЗДТГ, 11-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг зэрэг байгууллагуудад өөрсдийн хүсэлт гаргасны дагуу эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Цагдаагийн газарт баривчилгаанд саатуулагдаж буй 15 иргэнд “Гэр бүлийн сэтгэл зүй” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтын дараа 2 иргэнтэй гэр бүлийн асуудлаар сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ХБХЭМБНХМК-ын хурлаар 62 хүүхдийн асуудлыг хэлэлцэж 6 хүүхдийг шинээр тогтоож, 2 хүүхдийг цуцлаж, 54 хүүхдийн асаргааны тэтгэмжийг сургалт хийгдсэн болно.

Эрсдэлийн мэдээллийн санд 01 сарын байдлаар нийт 1506 хүүхэд бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс эрсдэлгүй 597, бага эрсдэлтэй 32, дунд эрсдэлтэй 29, өндөр эрсдэлтэй 848 хүүхэд байна. Эрсдэлгүй 403 хүүхдүүдийн шивэлтийг устгаж нийт 63 хүүхдийн мэдээллийг нэмэлтээр шивж оруулаад байна.

20112051 кодтой кейсийн асуудлаар ХЭҮК-т илтгэх хуудсыг хүргүүлсэн. Уулбаян суманд ажиллаж тухайн орчны нөхцөл байдалтай танилцаж, үнэлгээ хийж ажилласан. Шатахуун, томилолтын зардалд 106,000 төгрөгийг зарцуулсан болно.

Баруун-Урт сумын 2, 3, 6, 10-р цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн гишүүнд эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн судалгааны чиглэлээр зөвлөмж өгч ажиллав.

Баруун-Урт сумын Хамтарсан багийн гишүүдэд “Хамтарсан багийн бүтэц, гишүүдийн үүрэг”, “Нөхцөл байдлын үнэлгээ” хийх аргачлал, кейс хэлэлцүүлэг зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтанд 42 гишүүн оролцсон болно.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн 21 дуудлагын бүртгэлийн ажлыг хийж 8 дуудлагыг хаасан, 108 дугаараас 4, аймгийн Цагдаагийн газраас 2, нийт 6 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тус бүрт хувийн хэрэг нээж харьяа сумын “Хамтарсан баг”-т шилжүүлж удирдлага аргазүйгээр ханган ажиллаж байна. Сумдын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдтэй холбогдож мэдээллийг хүргэж ажилласан бөгөөд Наран, Мөнххаан, Баруун-Урт сумдад ХТУ-108 утаснаас ирсэн дуудлагын дагуу удирдлага аргазүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн эрх хамгааллын асуудлаар 14 иргэн хандаж зөвлөгөө, мэдээлэл авсан болно.

Байгууллагаын дэргэдэх “DIVAS DAILY” охидын клубын гишүүнд “Depression stress” сэдвээр мэдээлэл өгч удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Тус сэдвээр 2020 оны 12 сарын 28-нд клубын гишүүн болон дэмжигч хүүхдүүдэд чиглүүлэн тус клубын гишүүн Энэрэл зохион явууллаа.

Аймгийн шатрын холбоо, “Оюунлаг” шатрын клубтэй хамтран “Хөл хориог хөгжил болгоё” уриан дор Ковид-19 цар тахлын үед өөрийгөө хөгжүүлэх боломжийг нээх зорилгоор цахим шатрын тэмцээнийг 2-насны ангиллаар зохион байгуулж 35 хүүхэд оролцсон ба орон нутгийн телевизээр мэдээллийг түгээж ажилласан. Шагналд 148,000 төгрөгийг зарцуулсан.

Сүхбаатар аймаг- ажил, мэргэжлийн зөвлөгөө” фейсбүүк групп хуудсаар дамжуулан өсвөр үе, залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

Цагдаагийн газарт баривчлагдан хүмүүжиж байгаа 7 иргэнд “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт” буюу “Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн соёл”, “Уур бухимдлаа хэрхэн зохицуулах вэ” сэдэвт сургалтыг хийсэн.

Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Хорт зуршлаас татгалзах нь” сэдэвт подкаст ярилцлага хийж олон нийтэд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Цахим хандалт 2130.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Аймгийн Засаг даргын 2021 оны А/26 дугаар захирамжийн дагуу спортын төв заал, Б заал, усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлээд байна. Үйл ажиллагааг хэвийн горимд оруулахтай холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм сахих, аюулгүй ажиллагааны дүрэм журмаар ажиллах сургалт авсаны зэрэгцээ ариутгал халдваргүйжилт хийлгэсэн.

### Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр

Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд Сүхбаатар аймгийн 2020 хийсэн ажлын тайланг нэгтгэн хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргад холбогдох 2 Захиргааны хэрэгт Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцон, хариу тайлбарыг аймгийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан.

#### Цагдаагийн газар:

Нэг: Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил

Гэмт хэрэг	Хүний амь нас хохирсон	3
	Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	5
	Залилах	8
	Мал хулгайлах	3
	Цахимаар гүтгэх	2
	Хүчиндэх	2
	Хулгайлах	14
	Гээгдэл эд зүйл завших	5
	Бусдын орон байранд хууль бусаар нэвтэрсэн	1
	Эмнэлгийн тусламж зохих ёсоор үзүүлээгүй	1
	Сураггүй алга болсон хүн	1
	ЗТОсол	1
	<b>Нийт</b>	<b>48</b>
Зөрчил	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	36
	Эрхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон	54
	Гэр бүлийн хүчирхийлэл	17
	Зам тээврийн осол	8
	Хүний биед халдах	10
	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	1
	Гарал үүслийн гэрчилгээгүй мал тээвэрлэсэн	3
	Олон нийтийн газар танхайрах	7
	Хулгайлах	4
	Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн	1
	Гээгдэл эд зүйл завших	2
	ЦАХ-н шаардлага эсэргүүцсэн	1
	Хорио цээрийн дэглэм зөрчсөн	3
	Бусад	11
<b>Нийт</b>	<b>159</b>	
Эрүүлжүүлэгдсэн-21	Баривчлагдсан-14	Түр саатуулсан-44

Аймгийн Засаг даргын “Хүнс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах тухай” захирамжийн дагуу Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэн ирсэн 42 жолоочийг гэрийн ажиглалтад шилжүүлэн, хяналт тавьж байна.

Шинэ жилийн баярын үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Шинэ жил” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 2020 оны 12 дүгээр сарын 31-ээс 2021 оны 01 дүгээр сарын 03-ны өдрүүдэд батлагдсан хуваарь томилгооны дагуу 48 алба хаагч өдрийн болон шөнийн эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, корона вирусийн халдвар /ковид-19/-ийн цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэхэд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын төвд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг "Олон нийтийн эргүүл"-д ажиллуулах журам, хуваарийг санаачлан боловсруулж аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/701 дүгээр захирамжаар батлуулан долоо хоног бүрийн баасан гарагт хамтарсан эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна.

Цагдаагийн газрын “Дүн шинжилгээ судалгааны баг” энэ оны анхны хурлаа зохион байгуулж 2020 онд аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулан, аймаг, сумдын удирдлага, хууль хяналтын байгууллагуудад хүргүүлэв.

Бусдын эд зүйлийг хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сонор сэрэмж” хэсэгчилсэн арга хэмжээг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн олон дагагчтай аймгийн фейсбүүк группүүдээр олон нийтэд түгээх, томоохон зах худалдааны төвүүдээр явж иргэдэд зөвлөмж тараах ажлыг зохион байгуулж байна.

Хэсгийн төлөөлөгч нарын 2021 оны 1 дүгээр сарын цугларалтыг хорио цээрийн үеийн шаардлагад нийцүүлэн энэ оны 01 дүгээр сарын 20-ноос 21-ний өдрүүдэд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулав. Цугларалтаар алба хаагчдад 8 цагийн сургалт явуулж, холбогдох мэдээллийн сангуудад баяжилт хийлгэн, сарын ажлын үр дүнг үнэлж дүгнэн, үүрэг чиглэл өгсөн.

Цагдаагийн газраас гаргасан саналын дагуу Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2021 оны төсөвт шинээр нэмэгдсэн олон нийтийн цагдаагийн орон тоонд иргэдийг судалж, томилох зорилгоор газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг томилж, хүсэлт гаргасан 25 иргэнийг бүртгэн, сонгон шалгаруулалт явуулж байна.

Цагдаагийн газрын 76 алба хаагчийг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр PCR шинжилгээнд хамруулахад шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан.

**Улсын бүртгэлийн чиглэлээр:** 2021 оны 01 дүгээр сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:**

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-184, анхны бүртгэл-37, өмчлөх эрх шилжих гэрээ-28, барьцааны гэрээ-94, бүртгэлд өөрчлөлт оруулах -7, лавлагаа хуулбар-5, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-9

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-172, анхны бүртгэл-28, өмчлөх эрх шилжих гэрээ-42, барьцааны гэрээ-75, бүртгэлд өөрчлөлт оруулах -21, лавлагаа хуулбар-0 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-91, нийт бичигдсэн лавлагааны тоо-0

**Хуулийн этгээдийн улсын бүртгэл:** 01 дүгээр сарын 26-ны байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо 5 Үүнээс ХК-3, ХХК-646, төрийн бус байгууллага-1, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-0, нөхөрлөл-0, хоршоо-0, хадгаламж зээлийн хоршоо-0, сан-0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-1, шашны байгууллага-0, хэвлэл мэдээллийн байгууллага-0 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-0, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-0, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-5, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 5,

хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -11, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 3 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

**Иргэний бүртгэл:** Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны 01 дугаар сарын байдлаар нийт 90 төрөлт, гэрлэлт 53, гэрлэлт цуцлалт 4, үрчлэлт 1, эцэг тогтоолт 7, овог нэр өөрчлөлт 3, нас баралт 15, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 37, үндэсний энгийн гадаад паспорт 5, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 48, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 48 тус тус бүртгэгдэж олгосон байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр:** Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2021 оны 01 дүгээр сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 14 ялтны 53400000 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 17 ялтны 18100000 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 10 ялтны 5250000 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 21 ялтны 66250000 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эрх хасах ялын урьд оны 25 ялтны 11729 хоногийн үлдэгдэл дээр 6 ялтны 40015 хоногийн материал нэмэгдэж, 1 ялтны 365 хоногийн хугацаа дуусаж, үлдэгдэл 29 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 5 этгээдийн 19764000 төгрөг материал дээр шүүхээс шинээр 4 этгээдэд холбогдох 392000 төгрөгөөс 4 этгээдийн 5406000 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр:** 2021 оны 01 дүгээр сарын байдлаар төлбөрийн биелүүлбэл зохих 205 гүйцэтгэх баримт бичгийн 1853934.0 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 29 гүйцэтгэх баримт бичгийн 39418.3 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 14.1 хувьтай байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Албаны бие бүрэлдэхүүн цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хэргийн газрын үзлэгт 14 удаа оролцсноос, хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 4 удаа, хулгайн хэргийн дуудлаганд 4 удаа, зам тээврийн осол хэргийн дуудлаганд 3 удаа, бусад дуудлаганд 3 удаа явж хэргийн газрын үзлэгээр гарын мөр 1ширхэг, гутлын мөр 2 ширхэг, тээврийн хэрэгслийн мөр 1ширхэг, бусад ул мөр, эд мөрийн баримт 29 ширхэг, нийт 33 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан байна.

Тус албаны шинжээч эмч нар нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 53 удаа хийснээс хүндэвтэр 1, хөнгөн 24, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 14, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 14 дүгнэлт гаргасан байна. Мөн бэлгийн маргаантай хэрэгт 7 дүгнэлт гарган ажилласан.

Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 4 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Гэрэл зургийн чанарт онцгой анхаарч ажиллаж байгаа бөгөөд 1-р сарын байдлаар 372 кадр гэрэл зураг авагдсан байх ба хэргийн газрын үзлэгийн 238, цогцосны гадна үзлэг болон задлан шинжилгээний 74 кадр, бусад 60 кадр гэрэл зураг авагдсан.

Аймгийн Цагдаагийн газар баривчлагдсан 8 хүний гарын дардасыг авч, лавлагаа авах хүсэлтийн дагуу 8 хүний гарын хээний лавлагаа мэдээллийг албаны даргын зөвшөөрлөөр олгосон.

#### **Тав. Батлан хамгаалах салбарт**

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг хүссэн 11 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/39 дүгээр захирамжийн дагуу бэлтгэл офицер, цэргийн үүрэгтний бүртгэлийг 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар болж бүртгэлийг эхлүүлээд байна. Уг захирамжийн дагуу Цэргийн штабын тоо бүртгэл, Орон нутгийн хамгаалалт сургалт хариуцсан офицерүүд Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Мөнхаан сумдад ажиллаж, сумдын Тамгын дарга болон багийн Засаг дарга нарт Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн тоо бүртгэлийн талаар сургалт явууллаа.

#### **Зургаа. Бусад**

**Стандарт, хэмжил зүйн чиглэлээр:** Тохирлын гэрчилгээ сунгуулах 1 аж ахуй нэгжийн өргөдөл ирсэн байна.

8ш цусны даралтын аппарат, 10ш айл өрхийн 1 фазын цахилгаан тоолуур, 7ш жинг баталгаажуулан гэрчилгээжүүлсэн байна.

Хоол хүргэлтийн үйлчилгээний шинэ стандартыг 7 аж ахуй нэгжийн хүргэлтийн хоолны үйлчилгээнд сурталчилаж 5 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

### **Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил**

#### **Асгат:**

01 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсэг тус суманд ажиллаж Коронавирусын халдварын бэлтгэл бэлэн байдал, Улсын онцгой комисс, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын Сумын онцгой комисс, Засаг даргын тамгын газар, сумын Эрүүл мэндийн төвийн тусгаарлан эмчлэх байр, тусгаарлан ажиглах байрны тохижилт, ковидын хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариа, ариутгалын бодисын нөөц, хүн хүчний бэлтгэл бэлэн байдал зэргийг шалган, Тусгаарлан эмчлэх байр болон Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж үнэлсэн ба хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисын нөөцийг нэмэгдүүлэх, тусгаарлан ажиглах байрыг стандартын дагуу бэлдэхийг тус тус үүрэг болгосон байна.

#### **Баруун-урт:**

**Хууль эрх зүйн чиглэлээр:** Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу нийт албан хаагчдад ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлагнах журмын талаар сургалт хийж, мэдээлэл өгсөн.Сургалтад 40 албан хаагч хамрагдсан.

Тайван хот-таны оролцоо хөтөлбөрийн төслийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулсан.Мөн иргэдийн оролцоог хангах ажлын хүрээнд хөтөлбөрт тусгах саналыг иргэдээс цаасаар болон цахимаар авсан. Цаасаар авсан судалгаанд нийт өрхийн 5%-ийг хамруулсан. Цахим санал асуулгад 250 иргэн хамрагдаж санал бодлоо илэрхийлсэн байна.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Улс, аймгийн сайн малчин, алтан төлийн эзэн шалгаруулах журмын дагуу малчдын материалыг бэлтгэж, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.Үүнд:

Улсын сайн малчинд:8-р багийн малчин Тогоочийн Төмөрмөнх,

Алтан төлийн эзэнд:8-р багийн малчин Шагдарын Батсүрэн, Гомбожавын Баярхүү, 4-р багийн малчин Лодойн Ганбат

Аймгийн сайн малчинд:8-р багийн малчин Түмэнцогтийн Гантогоо, Дашбал Доржпалам, 2-р багийн малчин Дэнсмаагийн Энхжаргал зэрэг малчдын материалыг хүргүүлсэн.

Ковид-19 цар тахалтай холбогдуулан санаачилан зохион байгуулж буй “Хотынхондоо хониор туслая” аянд нэгдэж Баруун-Урт сумын иргэдээс 30 толгой хонь хандивласан.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 240 гаруй аж ахуй нэгжүүдэд коронавирусын эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлэх тухай зөвлөмж чиглэл өгч ажилласан. Уг ажлын хүрээнд 32 албан хаагч 16 хэсэгт ажилласан.

Сумын шуурхай штабын 7051-1111 дугаарт мэдээлэл өгөх нэг ажилтанг аж ахуйн нэгжүүд томилгоожуулж, үйлчлүүлсэн иргэдийн халууныг үзэж, хэдэн хүн үйлчлүүлсэн тоог өдөр бүрийн 10 цагт өгч хэвшсэн. 1-р сард 47 аж ахуйн нэгжээр 22243 иргэн үйлчлүүлсэн байна.

Хүнсний дэлгүүрүүд QR кодоор үйлчилж байгаа болон тусгаарлах байр гаргах боломжтой судалгааг 55 аж ахуйн нэгжээс авсан.

Тамхины зөвшөөрөл хүсэж өргөдөл өгсөн 16 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч хэмжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, хуулийн шаардлага хангасан 2 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.

**Байгаль орчин, дэд бүтэц, газар зохион байгуулалтын чиглэлээр:** Баруун-Урт хотын төвөөс мал гаргах ажлын хүрээнд багийн ажлын албатай хамтран багийн нутаг дэвсгэр дээрх малтай өрхийн судалгааг гарган, 23 өрхөд мэдэгдэл өгч ажиллаж байна. Мөн Сүхбаатар тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ газрын хашаанд хашигдсан 26 малын 3 иргэнтэй уулзаж сануулах арга хэмжээг авч, зөвлөгөө өгч ажилласан.

Сумын 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг олон нийтийн телевиз, цахим орчинд ил тод нээлттэй мэдээлж байна.

Замын цас, ил задгай хаягдсан 2м.күб хогийг цэвэрлэх ажлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран хийсэн.

Баруун-Урт сумын 9-р багийн нутаг дэвсгэрт шинээр зөөврийн усан сан барих тендерийн техникийн нөхцөл боловсруулах, зураг төсвийг бэлэн болгох бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

**Боловсрол:** Тайлант сарын байдлаар 7 кейс, 2020 оны 11-12 дугаар сард 15 кейс нийт 22 кейс ирснийг анхан шатны бүртгэл мэдээллийг хийж сумын хамтарсан багт танилцуулан ГБХЗХГ-т явцын мэдээг хүргүүлсэн. 22 кейсээс 3 кейсийг хааж, 19 кейс явц 50%-тай явж байна.

**Эрүүл мэнд:** Коронавируссээс сэргийлэх арга хэмжээний хүрээнд Улаанбаатар-Баруун-Урт чиглэлийн постод ажиллах эмчийг томилгоожуулан тус постын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд шаарлагатай хувцас хамгаалах хэрэгсэл эд зүйлсээр ханган ажиллаж байна.

Гэрийн ажиглалтад буй иргэдэд хяналт тавин ажиллаж байна. 1 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 1489 иргэн гэрийн ажиглалтнаас гарч 227 иргэн гэрийн ажиглалтанд байна.

УБ хотоос ирэх иргэдийг татах авах ажлын бэлтгэл хангагдаад байна. 230 иргэн ирэх бүртгэл хийсэн. Үүнээс 01 дүгээр сарын 26-ны байдлаар 4 автобус 80 иргэнг татан авч эхлээд байна.

#### **Баяндэлгэр:**

ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит бус 2 дугаар хуралдаанаар сумын малын тоо толгойн албан татварын хэмжээг Адуу – 1000, үхэр -1000, хонь – 600, ямаа – 800 төгрөг байхаар тогтоож баталлаа.

**Төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг Тендер gov .mn цахим санд нийтэлж илгээв.

Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу иргэдээс санал авах хуудсыг 6 баг тус бүр 100 ш хэвлэн багийн Засаг дарга нарт өгсөн .

**ЕБСургууль:** Аймгийн Онцгой комиссын 2 дугаар хурлын шийдвэрийн дагуу 12 –р ангийн сурагчид элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор 2021 оны 01 сарын 25 –наас 03 сарын 01 – ыг хүртэл халдвар хамаагааллын дэглэмээ баримтлан 10 мэргэжлийн хичээлээр нийт 81 сурагч хуваарийн дагуу танхимын сургалтад хамрагдаж байна.

**Хөдөө аж ахуй:** Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан сумын өвөлжилтийн өнөөгийн байдлын судалгааг гаргаж аймгийн ХХААГазарт шаардлагатай өвс, тэжээлийн захиалгыг хүргүүлсэн.

5 багийн 9 суурийн 525 ухна , 1003 хуцанд үзлэг тандалт хийхэд хуц -18, ухна -42 хорогдсон байна. Хуц, ухна маллаж байгаа малчдад сумын аюулгүй нөөцөөс 350 боодол өвс олгосон. Сумын хэмжээнд нийт 869 толгой мал хорогдсон. Үүнд адуу – 20, үхэр -57, хонь - 356, ямаа -436.

Улсын аварга малчинд -1, аймгийн сайн малчинд – 4-н малчны материалыг болзол журам шаардлагын дагуу бүрдүүлж хүргүүлээд байна.

Коронавирус гарсантай холбоотойгоор Улаанбаатар хот руу мах тээвэрлэж байгаа 19 машинд QR кодыг гаргаж өгсөн.

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит бус 2 дугаар хуралдаанаар Малын “ Эрүүл мэнд ” хөтөлбөр, Сумын гоц халдварт, зооноз, шимэгчтэх өвчнөөс эрүүлжих дунд хугацааны төлөвлөгөө /2020-2024/, Сумын 2021 оны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний төлөвлөгөөг оруулж батлуулсан.

#### **Дарьганга:**

Сумын ИТХ-ээлжит 4 дүгээр хуралдаанаар “Малын тоо толгойн татварын хувь хэмжээг” тогтоож, үхэр, хониноос 600 төг, адуу, ямаанаас 900 төгрөг, тэмээнээс татвар

авахгүй, 200 хүртэл толгой малтай малчин өрх, 100 хүртэл толгой малтай мал бүхий өрхийг тус тус татвараас чөлөөлөхөөр тогтлоо.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хянуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, 82 зорилт, 202 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хянуулан, зөвлөгөө авч, ИТХ-аар батлууллаа.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж сумын нэгдсэн дулаан халаалтын асуудал болон газар чөлөөлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл авч холбогдох арга хэмжээг авахаар боллоо.

Коронавирусийн халдварын тархалтын улмаас хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн нөхцөлд сумын ЖДҮ, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажлын байрыг хагалах зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-гийн 2018, 2019, 2020 оны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан, эргэн төлөлт хэвийн иргэн, аж ахуйн нэгжийн 2021.01.01-2021.07.01-нийг хүртэлх хугацааны зээлийн үндсэн төлбөр, хүүг нь түр хугацаагаар хойшлуулж, зээл төлөх үндсэн хуваарьт нь өөрчлөлт орууллаа.

**Сургалт сурталчилгааны чиглэлээр:** “Тохиолдлын удирдлагын тогтолцоо салбар хоорондын хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг аймгийн ОБГ, МХГ, ЭМГ-ын хамтарсан баг суманд ирж зохион байгуулж, 25 албан хаагчдад дадлага хийлгүүлж, үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Төрийн албан хаагчдад Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудыг танилцуулж, байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаар мэдээллийг цахимаар болон танхимаар өгсөн.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Ковид-19 болон Томуугийн дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж, цаг үеийн мэдээг холбогдох газруудад тухай бүрт мэдээллэн ажиллаж байна.

Олон нийтийн сүлжээгээр 120 удаагийн мэдээлэл, зөвлөмж зөвлөгөө оруулж хандалт 2335 байна.

Улсын хэмжээнд 3-5 насны хүүхдүүдэд “Халдварт саа”-гийн нөхөн дархлаажуулалт хийгдэж байгаатай холбогдуулан 32 хүүхдийг вакцинжуулаад байна.

**Хөдөө аж ахуй:** Сумын Засаг дарга болон орлогчоор ахлуулсан баг сумын I, II багийн малчин өрхүүдээр биечлэн очиж өвөлжилтийн байдалтай танилцан, цаг үеийн мэдээлэл өгч ажиллалаа. Нийт 84 хот айлаар орж мэдээлэл солилцоход малчид өвөлжилт хүндэрч болзошгүй, бэлчээр хүрэлцэхүй тул ядарч муудсан малыг тэжээлд оруулахад өвс тэжээл хэрэгтэй байгаагаар ажлын хэсэгт танилцуулсны дагуу зохих арга хэмжээг авлаа. Мөн энэ үеэр “Манлайлагч малчин өрх” шалгаруулах уралдааны болзлыг танилцуулсан.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, ширийг хоршоогоор дамжуулан тушаасан 265 малчдын баримт буюу хонины 266, ямааны 135, үхрийн 284 ширхэг паданыг программд шивж, аймгийн ХХААГ-т хүргүүлээ.

2020 оны хүн ам, мал тооллогын дүн мэдээг хугацаанд нь тушаасан. Үүнд: а/. Хүн ам 3126, өрх 929, малчин өрх 507, малтай өрх 287, мал бүхий өрх 797, нийт мал 224403 толгой тоологдсоноос тэмээ-159, адуу 24781, үхэр 22410, хонь 112388, ямаа 65180 байна.

Зудын эрсдлийн судалгааг гаргахад цагаанаар зудархуу гэж үнэлэгдсэн.

#### **Мөнххаан:**

Аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяраар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллах үеэр байгууллагуудын үйл ажиллагаа, сум орны өвөлжилтийн бэлтгэл ажил болон цаг үеийн ажлуудын талаарх мэдээлэл, тулгамдаж буй асуудлуудыг танилцууллаа.

Сумын засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2021 оны А/26 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЕБС, дотуур байрны бэлтгэл бэлэн байдал халдвар хамгааллыг хийж гүйцэтгэсэн байдалд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 8 ангид 7 хичээлийн 44 хүүхэд хичээл хийх бэлтгэл ажил хангагдсан байна.

2020 оны 01 сарын 28-ны байдлаар гэрийн ажиглалтад нийт 51 үүнээс хүүхэд -10, насанд хүрэгчид 40 , ажиглалтаас -1 гарч, нэмэгдсэн 6 хүн байна. 1 сарын 26-ны татан авалтаар 20 иргэн ирсэнийг гэрийн ажиглалтад авч хяналтыг хийж байна.

Хөдөлмөр эрхлэлт, халамж: 2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан нийт 26 иргэний 117,000,000 төгрөгийн эргэн төлөлтийн тооцоо нийлсэн актыг иргэнтэй тулган баталгаажуулахаас 17 иргэний тооцоог батлгаажуулан гарын үсэг зуруулаад байна.

Нийгмийн халамжийн сангийн олголт 357 иргэнд 36,260,070 сая төгрөгийн олголт хийсэн.

**Эрүүл мэнд:** Гэрийн ажиглалтад 12 хүнийг авч өдөр бүр хяналтын хуудсаар хянаж байна. Энэ сард ЭМТөвөөр нийт 953 хүн үйлчлүүлсэн. Эдгээр иргэдийн халууныг үзэж зөвлөгөө өгч ажиллалаа.

ЭМТ-ийн тусгаарлах хэсгийн завсрын бүсийг өргөтгөж шаардлагатай бүх зүйлсийг байршуулсан. Ногоон бүсийг шинээр тогтоож хаалга гаргасан.

**Хүнс, хөдөө аж ахуй:** 2020 онд мал аж ахуйн салбарт амжилт гаргасан 6 малчин үүнээс улсын аварга малчинд 1, аймгийн аварга малчинд 4 алтан төлд 1 малчдын материалыг аймгийн ХХААГ-т хүргүүлж ажилласан.

Хугацаа хэтэрсэн хадгалалтын горим алдсан хаяг шошигний зөрчилтэй 1101590 мян төгрөгний бүтээгдэхүүн хураан авсан.

#### **Наран:**

Багийн Засаг дарга нартай хамтран цэцэрлэгийн насны “Алслагдсан хүүхдийн судалгаа”-г гаргаж, 113 хүүхдийн эцэг эхтэй холбогдон томуу томуу төст өвчинтэй эсэх талаарх мэдээллийг лавласан. Судалгаагаар сумын төвд 78, хөдөө 32, бусад аймаг хотод 3 хүүхэд тус тус байна. Цахимаар “ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ХӨГЖИЖ БУЙ ХҮҮХЭД” сэдвээр хүүхдийн бүтээлийг байршуулах ажил явагдаж байна.

Сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд анги удирдсан багш нартай хамтран хүүхдийн нөхцөл байдлын болон эрсдэлийн үнэлгээг 4 сурагчид хийж хамтран гэрийн эргэлт хийж ажилласан.

#### **Онгон:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллах үеэрээ төсөвт болон төрийн өмчит 6 байгууллага, хилийн дугаар ангид ажиллаж ажилтан албан хаагчидтай уулзаж нийт 43 төрлийн чиглэлээр үүрэг өгсөн.

Цар тахлын үед Хандиваар 6.350.000 төгрөг хандиваар, төсвөөс 4.200.000 төгрөгийг зарцуулсан байна.

**Хууль, эрх зүй:** ИТХурал, ЗДТГазраас Хог хаягдлын хураамж батлах тухай шийдвэрийг Хууль зүй дотоод хэргийн яамаар хянуулж бүртгүүллээ.

Малын тоо толгойн албан татварын тогтоолын төслийн хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж хуулийн дагуу аймгийн ХОХБТХэлтсээр хянуулан дүгнэлт гаргуулж дүгнэлтийн дагуу засаж, сумын ИТХ-аар батлууллаа.

**Боловсрол, соёл, эрүүл мэнд:** Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд 2 дугаар сарын 1 нээс төгсөх ангийн сурагчдад танхимаар давтлага өгөх ажлыг зохион байгуулахаар болоод байна. Нийт 42 сурагчидад нэг ангид 17 хүүхэд байхаар тооцож давтлагын ажил эхлээд байна.

Сум дундын эмнэлэгээс гэрийн ажиглалтад 36 иргэнд тухай бүр ажиглалт тандалт хийж ажиллалаа. 01 дүгээр сарын 07-ны өдөр ойрын хавьтагч тус суманд ирсэн тухай

мэдээллийн дагуу нийт 35 албан хаагч 4 тээврийн хэрэгсэл 72 цагийн хугацаатай үүрэг гүйцэтгэсэн.

**Нийгмийн хамгаалал:** Хүн ам 3868 үүнээс эрэгтэй 1948, эмэгтэй 1920. Нийт хүн амын 49,64 хувь нь эрэгтэй, 50,36 хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг. Гадаадад 12 иргэн амьдарч байна. Нийт хүн амын 1369 нь 18 хүртэл насны, 427 нь 55 дээш насны иргэд байна.

Хөдөө аж ахуй: Нийт тоологдсон малын тоо-342129, өмнөх оны мөн үеийнхээс 10482 тоо толгойгоор өссөн. Үүнээс: Тэмээ-790, Адуу- 19693, Үхэр-25037, Хонь- 201736, Ямаа- 94873 тус тус тоологдсон байна.

Өвөлжилт хүндэрч сумын баруун урд тал, баруун тал, баруун хойд тал бүхэлдээ цасны зузаан нягтрал нэмэгдэж бог мал муудаж эхлээд байна. Сумын ЗДТГазрын ХАА-н тасгаас аймгийн ХХААГазарт 1000 боодол өвсний захиалга хүргүүлээд байна.

### **Сүхбаатар:**

Сумын ИТХ-ын ээлжит 2-р хуралдаан 2021 оны 01-р сарын 11-ний өдөр хуралдаж 2021 оны төсвийн тодотгол, ИТХ-ын төлөөлөгчдийн ёс зүйн дүрэм, ИТХ-ын Хороодын бүрэлдэхүүн,ажиллах журам, Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох тогтоол, Зарим газар нутгийг Орон нутгийн тусгай хамгаалтанд авах тухай тогтоол, Малжуулах хөтөлбөрийн журмын нэмэлт өөрчлөлт, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэлийн тайлан, Малжуулах хөтөлбөрийн тайланг сонслоо.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01-р сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Сумын ИТХ-ын ээлжит 2-р хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 11 өдөр хуралдаж орон нутагт малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг хонь-500, ямаа-900, үхэр-700, адуу-1200, тэмээ-0 байхаар тогтоож, тухайн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 заалтыг үндэслэн малчин нэг өрхийн 150, үүнд Хонь 100, Ямаа 30, Үхэр 10, Адуу 10 толгой малыг татвараас чөлөөлөхөөр тогтоол батлагдлаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/658 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын А/161 дугаар захирамжаар сумын 2020 оны өрх, хүн ам, хөдөө аж ахуйн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 35 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Сумын хэмжээнд нийт өрх 1075 болж өмнөх оноос 35 өрхөөр өссөн байна. Нийт хүн ам 3423 болж өмнөх оноос 77 хүнээр өссөн байна. Эрэгтэй 1629 хүн, эмэгтэй 1359 хүн амьдарч байна. Малтай өрх 897, малчин өрх 736, малчдын тоо 1279 байна.

Сумын хэмжээнд мал 381369 болж 4 төрөл дээрээ өссөн байна. Үүнээс тэмээ 1083 толгой, адуу 35598 толгой, үхэр 24719 толгой, хонь 211467 толгой, ямаа 108502 толгой болж өмнөх оноос 21651 толгой малаар буюу тэмээ 34-оор ухарч, адуу 3049 толгой, үхэр 1643 толгой, хонь 9875 толгой, ямаа 7118 толгой малаар тус тус өссөн байна.

### **Түвшинширээ:**

Монгол Улсын Засгийн газрын “Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах үүднээс “Иргэн таны сонорт” “Ковид-19 зөвлөмж” санамж хуудаснуудыг бэлтгэн 400 ширхэгийг хэвлэж сумын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд тараан сурталчилсан.

Тус суманд ажиллаж байгаа төсвийн 5 байгууллага, 2 банк, 2 ШТС, 7 аж ахуй нэгжид QR кодыг үүсгүүлэн нэвтрэх хэсэгт байршуулж иргэдэд сурталчилан таниулах ажлыг 2021.01.04-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлээд байна. Байгууллагууд QR код уншуулан иргэдийг бүртгэх ажил тогтмолжоод байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбогдуулан, цахимаар болон жилийн эцсийн мал тооллоготой хамтатган 439 малчин иргэнээс санал авч, сумын ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны хуралдаанаар адуу-1000, үхэр-800, хонь-300, ямаа-600 төгрөгийн татвартай байхаар тус тус тогтоосон байна.

**Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Золбин нохой устгалын ажлыг сумын төв болон хөдөөгийн багийн төвд зохион байгуулан 90 нохой устгаж, нэгдсэн хогийн цэг дээр халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж булж устгасан.

Хувийн хэвшлийн малын эмч нар ЗДТГ, Цэцэрлэг, дэлгүүрүүдийн гадна, нийт 4800 мкв талбайд ариутгал халдваргүйтэл хийсэн байна.

Суманд ашиглаж байгаа мал угаалгын ванны судалгааг гаргаж аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлэв. Тус суманд ашиглаж буй 5, засвар шаардлагатай 3, шаардлага хангахгүй ашиглах боломжгүй 3, зөөврийн 2, нийт 14 угаалгын ванн байна.

Улаанбаатар хотруу хүнсний тээвэрт явж байгаа ачаа тээврийн машинуудад QR кодыг 8 иргэний автомашинд олгосон.

2020 оны өрх, хүн ам, малын жилийн эцсийн тооллогын нэгдсэн дүнгээр сумын хэмжээнд 830 малтай өрх, 6 тавиул малтай өрх, 4 аж ахуйн нэгжид 314713 толгой мал тоологдсон байна. Үүнд: Тэмээ-1145, Адуу-17355, Үхэр-15631, Хонь-163434, Ямаа-117148 толгой мал тус тус тоологдсон байна.

Нийт хүн ам 3425 болж, өмнөх оныхоос 24 хүнээр өссөн дүнтэй байна. 2020 онд 72 хүүхэд шинээр мэндэлж, шилжин ирсэн хүн ам 29, шилжин явсан 46, нас барсан 31 хүн, шижиж ирсэн хүнээс 11 хүн нь өөрийн аймгийн сумдаас, 28 хүн нь бусад аймаг, сумдаас ирсэн байна. Шилжин явсан хүн амын 34% өөрийн аймаг дотроо, 66% гадны аймаг, сумдруу шилжин явсан ба Дорногвь аймгийн Хөвсгөл сум-1, Хэнтий аймгийн Хэрлэн сум-2 өрх шилжиж ирсэн байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шинээр асаргааны тэтгэмж тогтоолгох 2,асаргаа сунгуулах 5 хүний,хүнсний эрхийн бичигт хамрагдах 1 өрхийн асуудлыг хэлэлцсэн.

2021 оны 01-р сарын 07-ны ХТДҮҮ-нд 26 өрхийн 115 иргэн хамрагдаж байна. 56 ажил хайгч иргэний мэдээллийг дахин сэргээсэн. 2021 оны 1-р сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээний болон ажил хайгчаар бүртгэгдсэн иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

**Боловсрол:** Сургуулийн Улаан загалмайн, Скаутын холбооны хүүхдийн хүүхдийн оролцооны байгууллагын суралцагчдын хүүхдүүд нь 55000 төгрөгний хүүхдийн бэлэг, хүнсний зүйлийг зорилтот бүлгийн 1 гэр бүлд тусламж үзүүллээ.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг малчид иргэдтэй уулзах ажлаар явахад багш нарыг томилон ажиллуулж байна. Эхний ээлжинд бага ангийн 72, дунд ахлах ангийн 52 нийт 124 сурагчийн хэвлэмэл даалгаврыг хүргэж ажиллалаа.

**Эрүүл мэнд:** Сумын Засаг даргын 2021 оны А/02 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж шаардлагатай нэг удаагийн хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх зэрэг ажлуудыг шат дараатай хийж байна.

ЭМТ-ийн нөөцөд өнөөдрийн байдлаар 1 удаагийн комбинзон-240, 1 удаагийн маск-850, 1 удаагийн малгай-38ш, 1 удаагийн халад-150ш, бээлий-500, улавч-450, хормогч-4, шүүлтүүртэй маск-88ш, нүдний шил-90ш, нүүрний хаалт-47ш, ахуйн бээлий-20, усны гутал-10, цогцос хадгалах уут-1, аюултай хог хаягдлын уут-5 боодол жавелин-1500ш, хлорын шохой-15кг, санитол-10 л тус тус байна.

2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр нэг удаагийн халад 300ш, улавч-200, хүзүүвч-300, амны хаалт-3000, АЦЦ уухаар, витамин С, глюканат кальци- тус тус хангалтаар ирээд байна.

Коронавирусын бэлэн байдалыг хангах ажлын хүрээнд тохиолдолд суурилсан дадлага сургуулалтыг 2 удаа явуулаад байна. Эрүүл мэндийн сайдын 375 тоот тушаалын дагуу

давхардсан тоогоор 41 удаа аж ахуй нэгж байгууллагуудад тандалт хийгдээд байна. Халдвар хамгаалалын хувцасыг хүн бүр 20 удаа өмсөж тайлах аян явагдаж байна.

#### **Түмэнцогт:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Засаг даргын А\07 тоот захирамжаар Малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох санал асуулга хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулж саналыг нэгтгэн сумын ИТХуралд танилцуулан татварыг тогтоосон .

Засаг даргын А\09 тоот “Шуурхай бүлгийн гишүүдийг томилох тухай” захирамжаар шуурхай бүлгийн гишүүдийг шинэчлэн томилж үүрэгжүүлсэн.

Засаг даргын А\05 тоот захирамжаар сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохиуцуулах, хяналт тавих ажиллагааг холбогдох хууль тогтоом, заавар журмын хүрээнд хариуцлагатай гүйцэтгэж ажиллахыг комиссын гишүүдэд үүрэг болгосон.

**Байгаль орчны чиглэлээр:** Уул уурхайн тээвэр хийх авто замын чиглэлийг Засаг даргын захирамжаар тогтоож, замын засвар, арчлалтыг хийж байхыг үүрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн БОАЖГазраас ирүүлсэн албан тоотыг үндэслэн зөвшөөрөлгүй гаргасан 1 худаг уст цэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж хялбаршуулсан журмаар зөрчлийг хянан шийдвэрлэж прокурорын хяналтад хүргүүлсэн.

**Хууль эрх зүйн чиглэлээр:** ЕБСургуулийн холбогдох албан тушаалтанд Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын дагуу цахим сургалт зохион байгуулсан.

Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 45 төрлийн мэдээллийг цахим группуудээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

**Мал эмнэлгийн тасаг:** Хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийн 2020 оны үр дүнгийн гэрээнд дүгнэлт хийн Мал эмнэлгийн газарт хүргүүлээд байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор төв зам дагуу дамжин өнгөрч байгаа техник болон мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт хийн ажиллаж байна.

**Хөдөө аж ахуйн тасаг:** Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч 2 багийн 92 өрхийн 61249 мян.толгой мал өвс тэжээлийн хомсдолд орж 150 тн өвс, 30 тн хивэг тэжээл шаардлагатай байгааг аймгийн ХХААГазарт хүсэлтээр хүргүүлээд байна.

COVID -19 цар цахалтай холбогдуулан хүнсний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж дэлгүүрүүд цаасан бүртгэл болон QR кодыг ашиглан үйлчлүүлэгчдийн бүртгэлийг хийж хэвшүүлж байна.

Засгийн Газрын 2015 оны 122-р тогтоолын дагуу 54 малчин, мал бүхий өрхийн 107 ш падаанд 2931 ш арьс ширний урамшууллыгн падаан бичигдснийг шивэлт хийж баталгаажуулан падааны хамт аймгийн ХХААГазарт хүргүүлээд байна.

“Аймгийн сайн малчин”-нд сумаас 2 малчны материалыг хүргүүлсэн.

Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол адуу – 14, үхэр - 22, хонь -1185, ямаа – 248, нийт – 469 толгой мал хорогдож сумын нийт малын 0,34%-ийн хорогдолтой байна.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр:** Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний бүртгэлийг мэдээллийн санд бүртгэсэн.

Сумын борлуулалтын цэгийн нэр төрлийг нэмэгдүүлж сурталчилан түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Түмэнцогт суманд үйлдвэрлэв” нэртэй цахим хаяг нээн зарагдсан болон худалдаалагдаж байгаа, шинээр нэмэгдсэн бараа бүтээгдэхүүний мэдээллийг байршуулж ажиллаж байна. 1 сарын байдлаар нийт 865,000 төгрөгний бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн байна.

Сумын иргэдэд Хөдөлмөр эрхлэлт болон Халамжийн чиглэлээр хэрэгжиж байгаа үйл ажиллагааг суртачилах, мэдээ мэдээлэл өгөх зорилгоор “Хөдөлмөр, халамж Түмэнцогт сум” нэртэй цахим хаяг нээж иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажиллаж байна.

АДЗөвлөлийн хурлаар 2 удаа хуралдуулж ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагдсан 3 ахмад настны асаргааны сунгалт, хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдийн

асаргааны сунгалтыг тус тус сунган, хэлэлцэж хурлын тэмдэглэлийг холбогдох хувийн хэргийн хамт мэргэжилтэнд хүргүүлсэн.

**ЕБСургууль:** Хичээлийн 2-р байранд Мобиком корпорацитай гэрээ байгуулан мобинэт тавиулж цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн

Оторт нутаглаж байгаа малчин өрхийн суралцагчдын судалгаа хаана амьдарч байгаа талаар судалгааг 2 удаагийн давтамжтай авч танилцууллаа. Гадны аймаг, суманд оторч өвөлжиж байгаа 6 суралцагч байна. Сумын төв дээр байгаа 349 суралцагч, 166 хөдөө гэртээ байгаа суралцагч, 13 суралцагч УБ хотод түр явж байгаа, өөрийн аймагт явж байгаа 4, өөр аймагт явж байгаа 5, гадаад оронд явж байгаа 2 суралцагч байгаа гэсэн нэгтгэл хүргүүлээ.

Хичээлийн 2 байранд QR кодтой болсон

Теле хичээл эхлэхтэй холбогдуулан урьдчилсан судалгааг авч БСУГ-т танилцуулсан. 97% үзэх боломжтой, 3% үзэх боломж муутай гэж өгсөн байна

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Нийгмийн даатгалын хуулийн сурталчилгааны ажлыг цахимаар иргэд даатгуулагчид сурталчилан ажилласан.Шимтгэл төвлөрүүлэх ажлыг иргэд даатгуулагчидтай утасаар холбогдож төвлөрүүлж байна.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахимаар өдөрт 3-5 удаагийн мэдээллийг бэлтгэн сумын болон өөрийн Facefook хаягаар иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.

**Цэцэрлэг:** Гэр бүлийн орчинд теле болон цахим сургалт явагдсан ч зарим сургалтын агуулгыг бататгахад нь дэмжлэг болох бие даан гүйцэтгэх, эцэг эхтэйгээ гүйцэтгэх дасгал даалгаврыг боловсруулан хэвлэмэл хэлбэрээр гарган Дунд, Ахлах "А", "Б", Бэлтгэл "А", "Б" бүлгийн багш нар нийт 1078 ширхэг хэвлэмэл хуудастай дасгал даалгаварын ном, эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөгөө зөвлөмж 109 ширхэгийг боловсруулан бэлтгэж, хүүхдүүддээ захидал бичин тарааж эхэлсэн бөгөөд 2021-01-25 ны байдлаар 92 хүүхдэд хүргэгдээд байна.

**ЭМТөв:** Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 28 иргэнийг гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж ажиллалаа.

Сумын 4 багийн 1527 өрхийг өрх тус бүрээр нарийвчилсан судалгаа гаргаж эрүүл мэндийн бүлгээр ангилсан.

ЭМТ нь 2020 оны 1 сарын 15 наас эхлэн өөрийн QR кодыг байршуулж үйлчлүүлэгч иргэдийг QR кодыг уншуулж нэвтрэхийг зөвлөж байна. Мөн Короновируст халдвар гарсан үед хэрэглэгдэх хамгаалах хувцас хэрэгсэл , тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж эмч эмнэлгийн ажилчдыг хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дадлага сургалтыг хуваарь гарган хуваарийн дагуу хийж байна. Ковид-19 халдварын бэлэн байдлыг ханган нөөц бүрдүүллээ.

### **Уулбаян:**

**Төсөв санхүүгийн чиглэлээр:** 12 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 58540.0 мянган төгрөг орохоос 118456.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 202.3 хувийн биелэлттэй байна.

2020 онд аймгийн санхүүгийн дэмжлэг 462470.7 мянган төгрөг ирэхээс 462470.7 мянган төгрөг ирж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх 11 ажил хийгдэхээс 9 ажил хийгдэж 175326.2 мян төгрөг төлөвлөснөөс 115778.2 мян төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

**Байгаль орчин:** СунХунголд ХХК-ны зөрчлийг арилгуулах тухай албан шаардлага хүргүүлсэний дагуу зөрчлийг биелэлтийг танилцах зөрилгөөр ажлын баг гарган сумын Засаг дарга, Хурлын дарга, Байгаль хамгаалагч, иргэдийн төлөөлөгч нар очиж танилцсан.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** 2020 оны байдлаар Уулбаян суманд 903 өрхийн 2978 хүн амьдарч байна. Үүнээс малчин өрх 603 мал бүхий өрх 96 байна. 2020 онд 241807 мал тоологдсон байна. Малын тоо толгойг 5-н төрлөөр авч үзвэл тэмээ-767, адуу 17950, үхэр-14079, хонь- 131285, үхэр- 77726 тоологдсон байна. 2019 оны тоотой харьцуулахад тэмээ-94, хонь- 5126-аар буурсан бол адуу-686, үхэр-571, ямаа-300 –аар өссөн байна. ИТХурлаар

малын хөлийн татварын хувьд адуу- 1000 төг, үхэр-400 төг, хонь-300 төг , ямаа-600 төгрөгийн татвар авхаар тогтоосон. 1 өрхөөс 150 толгой мал чөлөөлөхөөр адуу-10ш , үхэр-10ш , хонь-100ш , ямаа-30 ш гэж тогтоогдсон.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 3408.0 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Сайн дурын даатгалд 30 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулсан 1482.8 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 32 даатгуулагчийг даатгаж 1925,2 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

**Эрүүл мэнд:** Урьдчилан сэргийлэх үзлэг-105, амбулаторийн үзлэг –58, гэрийн идэвхтэй үзлэг-0, идэвхтэй хяналт-10, гэрийн дудлага-18, алсын дуудлага-16, артерийн даралт – 105, чихрийн шижингийн үзлэг-105, хөхний үзлэгт-14, эсийн шинжилгээнд-0, 0-2 насны урьдчилан сэргийлэх тарилгад-32, саагийн нэмэлт дархлаажуулалтанд-35 нийт 173

**Ерөнхий боловсролын сургууль :** “Хүүхэд хамгаалал”, “Ахуйн осол”, “Ковид 19” сэдвээр багш нар нийт 39 шторк бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулав.

Сумын ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран “Хүүхдийн аюулгүйн 10 дүрэм”-ээр 2-5, 6-9 дүгээр ангийн суралцагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулж 21 хүүхэд оролцов. 26 багш, удирдах ажилтан 38 онлайн сургалтад хамрагдсан.

**Хүүхдийн цэцэрлэг:** Багш нар 2-5 насны хүүхдийн байршлын судалгааг гаргаж, хөдөө байгаа малчин өрхийн 55 хүүхэдэд теле хичээлийн агуулгыг олгох зорилгоор 118 ширхэг хэвлэмэл гарын авлага боловсруулаад байна.

**Соёлын төв:** Цахим арга хэмжээний хүрээнд нийт 9 роман болон өгүүллэг иргэдэд хүгээд байна. Мөн Цахим орчинд Монгол үндэсний өв соёл болох зүйр үг болон аман хэллэгийн давалгаа явуулан ажиллаж байна.

#### **Халзан:**

**Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр:** Сумын ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр хуралдан малын тоо толгойн албан татварыг 5 төрлөөр нь тогтоон ажиллалаа. Адуу-1000 төгрөг, хонь-500 төгрөг, үхэр-500 төгрөг, ямаа -600 төгрөг байхаар шийдвэрлэлээ. Мөн малын тоо толгойн албан татвараас малчны амжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар хурлын тогтоол шийдвэр гарч холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа. Мөн сумын зарим газар нутгийг тусгай хамгаалалтанд авахаар хурлын тогтоол шийдвэрүүд нь гарлаа.

**Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Сумын Засаг дарга 3-р багийн иргэд малчин өрхүүдээр явж, өвөлжилтийн байдалтай танилцаж ажилласан.

**ЭМТөв:** 1 дүгээр сард гэрийн ажиглалтад 10 иргэн байна. covid Шинжилгээг– 4 хүнд түргэвчилсэн тестээр хийхэд сөрөг гарсан. 2021 оны 1дүгээр сард нийт үзлэг 120, үүнээс 10 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн байна.

**Хөдөө аж ахуй:** Улсын аварга малчны 1 материал, Аймгийн сайн малчны 4 материалыг болзлын дагуу бэлтгэж холбогдох газарт хүргүүллээ.

Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу Арьс ширний урамшуулалд 199 өрхийн хонины арьс-15541, ямааны арьс-1739, адууны шир-55, үхрийн шир-8326 бүгд 25660 арьс ширний материалын жагсаалтыг холбогдох газарт хүргүүлсэн байна.

**Байгаль орчны чиглэлээр:** Баян шарга уулын орчмын 190887.965 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай тогтоолын төслийн боловсруулан сумын ИТХ-ын 3 дугаар хуралдаанд оруулж батлуулсан.

### **Эрдэнэцагаан:**

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийг сумын иргэд, даатгуулагчдад сурталчлах ажлыг зохион байгуулах зорилгоор ЭРДЭНЭЦАГААН НИЙГМИЙН ДААТГАЛ цахим групп нээж 200 орчим иргэдэд мэдээлэл хийж, төсөвт байгууллагын нягтлан бодогч 9, ААН-н дарга эрхлэгч, ня-бо 35 нартай холбогдон Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар цахим мэдээлэл хүргэсэн. Мөн Хилийн 0146-р ангийн 28 албан хаагчдад Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар мэдээлэл сурталчилгааг хийж 11 даатгуулагчийг гар утасны АПП-д хамруулсан.

**ХАА-н тасаг:** 2020 оны жилийн эцсийн тооллогоор мал 5-н төрөл дээрээ өсөж нийт 398 889 толгой малтай болж, тэмээ 734, адуу 47 457, үхэр-29915, хонь 155 835, ямаа 164 948 толгойд хүрсэн байна.

Өвс тэжээлийн хомсдолд орсон өрхүүдийн судалгааг багийн засаг дарга нараар гаргуулж, зах зээлийн үнээс хямдруулж 1 боодол өвсийг 3500 төгрөгөөр борлуулсан.

**Хүнс худалдаа үйлчилгээ:** 11 ААН байгууллагад Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Сум хөгжүүлэх сангаас зээлтэй иргэдтэй уулзаж 2020 оны зээлийн үлдэгдлийн баталгаа хийлгэж авсан.

**Эрүүл мэнд:** Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу нийт 291 өвчний учир амбулатор- 160 хүнд үзлэг хийснээс, 36 урьдчилан сэргийлэх үзлэгт, идэвхитэй хяналтаар 52, гэрийн идэвхитэй үзлэг- 30 гэрийн дуудлага- 13 стационараар 16 нийт хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

1-р сарын байдлаар 13 эхийг жирэмсний хяналтанд авч 13 эхийг эхний 3 сартай хяналтанд хамруулснаар жирэмсний эрт хяналтын хувь 100 % байна.

**ЕБС:** 12-р ангийн сурагчдын давтлагыг 1-р сарын 25-ны өдрөөс эхлүүлэхээр Аймгийн Онцгой Комиссийн шийдвэр гарсантай холбогдуулж давтлага хийх анги танхимын ариутгал халдваргүйжилт хийх хуваарь гарган сургуулийн орчинд гаднаас орж, гарч байгаа хөдөлгөөнийг байнга хянах, тэмдэглэл хөтлөх, халуун хэмжих бүртгэл хөтлөх бэлтгэлийг хангаж ажиллалаа.

**Соёл:** Номын сангаар 11 хүн ирж үйлчлүүлж гэрээр 21 ширхэг ном гаргалаа. 2 хүнийг Биет бус өв тээгчээр бүртгэн бүртгэл мэдээллийн сангаа баяжууллаа.

**Хүүхдийн 2-р цэцэрлэг:** Бүлгийн багш нар цахим хичээлүүдийг бэлтгэж технологийн сандаа баяжилт хийсэн. Үүнд: “Хөдөлгөөн эрүүл мэнд” хичээлээр, “Хэл яриа”, “Хөгжим”, “Туршилт танин мэдэхүй”, “Математик энгийн төсөөлөл” зэрэг сэдүүдээр цахим хичээл бэлтгэж цахим сан бүрдүүлсэн.

**Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар**